

Манай түүхийн судалгаанд арга зүйн хувьд харгалзвал зохих зарим философи баримтлал

Товчлол. Өрнөдөд түүхийг танин мэдэхүйд арга зүйн хувьд шинэчлэгч, өөрчлөгч нөлөө бүхий байсан бөгөөд эдүгээ ч тэр нөлөө нь тодорхой байдлаар хадгалагдсаар буй, тийн атал түүхийн философиор бичсэн бүтээлүүдэд сайндаа цөөнхийнх нь бүтээл нэр дурдагдах төдий байдаг тийм зарим философичдын энэ сэдэвт холбогдох онолын баримтлалуудаас эл өгүүлэлд онцлон авч үзлээ. Зохиогч энэ зорилгоо биелүүлэхдээ германы философич, хэл шинжээч Вильгельм фон Гумбольдт (1767-1835), австрийн философич, логикч Людвиг Витгенштейн (1889-1951) нарын лингвистик философи баримтлалууд, францын философич, угсаатны зүйч Клод Леви-Стросс (1908-?) -ын структурализм, мөн францын философич Мишель Фуко (1926-1984) -гийн структуралист ба түүнээ засварлан бий болгосон постструктуралист философидолт, бас л францын философичид болох Жак Деррида (1930 онд төрсөн), Жан-Франсуа Лиотар (1924 онд төрсөн) нарын постмодернист баримтлал зэрэг аваас XX зууны сүүлийн хагасаас хойшхи Өрнөдийн түүхийн судалгаанд арга зүйн хувьд чухал нөлөө үзүүлж ирснийг эл өгүүлэлд нотлон бичсэн болно.

Түлхүүр үгс. Түүхийн философидолтын уугуул орон зай, баримтуудын “дүр”, бриколлаж, мэдлэгийн археологи, мэдлэг эрх мэдлээр тодорхойлогддог байдал, түүх аваас тохиолдлуудын хэлхээгээр тодорхойлогддог байдал.

1990-ээд оноос хойш Монголд түүхийн философи асуудлыг зөвхөн марксист-ленинист сургаалын агуулга, арга зүйд тохируулан тайлбарладаг монист байр сууриас татгалзсан бүтээл цөөн ч гэсэн гарах болж, улмаар энэ чиглэлээр сургалтын материал хэвлэгдэж, холбогдох суралцагчдад чухал хэрэглэгдэхүүн болж байна.¹

Түүхийн мэдлэгийн судалгаа, сургалт, сурталчилгааны арга зүйн үндсийг олон ургальч үзлийн зарчмын үндсэн дээр төлөвшүүлэхэд ийнхүү зарим ололт манайд бий боллоо. Үүний зэрэгцээ уг ажлыг онол, арга зүйн орчин үеийн төвшинд жинхэнэ ёсоор хүргэхэд философичид, түүхчид зэрэг хүмүүнлэгийн ухааны салбаруудын судлаачдаас хийх шаардлагатай зүйл багагүй байна. Тухайлбал монгол зохиогчдын бичсэн төдийгүй гадаадын олон

¹ 2002 оны хавар МУИС-ийн НУФ-ийн багш нарын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлдээ үндэслэн энэ өгүүллийг бэлтгэв. Зохиогч.

судлаачдын бичсэн холбогдох бүтээлүүдэд түүхийн зарим судалгаанд шууд ба шууд биш утгаар арга зүйн чухал нөлөө үзүүлж ирсэн янз бүрийн чиглэлийн философи баримтлал, тэдгээрийн зохиогч нарыг дурдахгүй өнгөрч, эсвэл зөвхөн сөргөөр хандаж байна. Зарим баримт дурдъя.

Америкийн зарим их сургуулийн профессоруудаас эрхлэн бэлтгэж хэвлүүлсэн философийн толь бичгүүд² дэх түүхийн философид зориулсан өгүүлэлд, мөн Оросын зохиогч нар болох И.А.Гобозовын "Түүхийн философийн удиртгал" (1999)³, А.И.Ивиний "Түүхийн философи" (2000)⁴ зэрэг номонд И.Г.Гердер, Дж.Вико, Г.В.Ф.Гегель, К.Маркс ба Ф.Энгельс, О.Конт, Ф.Ницше, Н.Л.Данилевский, XIX зууны сүүлийн хагасын шинэ кантч философичид мөн В.Дильтей, Г.Зиммель, М.Хайдеггер, О.Шпенглер, А.Тойнби, П.А.Сорокин, Р.Арн, Р.Ж.Коллингвуд, К.Ясперс, У.Дрей, Ю.Хабермас, С.Хантингтон, Ф.Фукуяма, Ф.А.Хайек зэрэг сэтгэгчийг түүхийн философийн гол төлөөлөгчид хэмээн онцлон авч үзжээ. Мөн 1990-ээд оноос хойш Орост хэвлэгдсэн философийн янз бүрийн толь бичигт ийм үнэлгээ давтагддаг юм.⁵ Эдгээр сэтгэгчдийн түүхийн философи сургаалыг онтологи маягтай, шүүмжлэлт маягтай хэмээн судлаачид ангилж ирсэн уламжлалтай билээ.

Гэтэл угтаа бүр XIX зууны 20-30-аад онд зарим нь үүсээд түүхийн философийн янз бүрийн чиглэлд арга зүйн хувьд шинэчлэгч, өөрчлөгч нөлөө бүхий байсан бөгөөд эдүгээ ч тэр нөлөө нь тодорхой байдлаар хадгалагдсаар буй, мөн сүүлийн хэдэн арван жилд үүсээд тийм ач холбогдол бүхий болсон зарим философи баримтлалыг болон тэдгээрийн зохиогч нарыг эдгээр бүтээлд дурдахгүй юм уу нэн ховор дурддаг тал илэрдэг юм. Ийм дутагдлыг засахад хувь нэмрээ оруулахыг энэ өгүүлэлдээ зохиогч хичээж байна.

Хэл шинжлэлийн философи ба түүхийг танин мэдэхүй. Хэл шинжлэлийн философийн олон чухал баримтлал түүхийн философид арга зүйн хувьд хүчтэй нөлөө үзүүлэх үндэстэй байдаг.

Хэл шинжлэлийн философи аваас философийн бие даасан салбарын хувьд XX зууны эхний хагасын бүтээгдэхүүн мөн. Гэхдээ бүр XIX зууны 20-30-аад онуудад түүний үр хөврөл бүрэлдсэн байжээ. Тийм үр дүн бий болгосон нэг гавъяатан бол германы философич, хэл шинжээч Вильгельм фон Гумбольдт (1767-1835) мөн. Г.В.Ф.Гегелийн үеийн энэ сэтгэгч бол танин мэдэхүйн үр дүнг зөвхөн рационализмд нийцүүлэн тайлбарлахаас зайлсхийсэн анхны томоохон сэтгэгчдийн нэг юм. Тэрээр 1822 онд бичсэн "Хэлний шинж ба ард түмний шинж" хэмээх өгүүлэлдээ: "үгс ба үгсийн хэлбэрүүд аваас ойлголтуудыг бүрдүүлэн, тодорхойлж байдаг бөгөөд янз бүрийн хэл мөн чанараараа болон танин мэдэхүй, мэдрэхүй хоёрт үзүүлдэг нөлөөгөөрөө ертенцийг өөр өөрөөр үзэхүй үнэхээр мөн"⁶ гэж бичиж байжээ. Тэрээр энэ санаагаа цаашдын бүтээлүүддээ улам бататган гүнзгийрүүлсэн аж. Тухайлбал 1830-1835 оны хооронд

бичсэн “Хүн төрөлхтний хэлнүүдийн байгууламжийн ялгаа ба хүн төрөлхтний оюуны хөгжилд уг байгууламж нөлөөлдөг тухай” хэмээх бүтээлдээ: “...хэл бол сэтгэлгээг бүрдүүлэгч эрхтэн мөн... Хэлийг үхмэл бүтээгдэхүүн биш, харин бүтээгч үйл явц мөн гэж үзэх ёстой. Энд хэл бол юмсыг тэмдэглэхийн тулд байдгаас, мөн харилцааны хэрэгсэл болж оршдог байдлаас хөндийрч, үүний хамт хэл бол дотоод оюуны үйл ажиллагаатай нягт холбоотойд болон энэ хоёр үзэгдэл харилцан нөлөөтэй байдаг баримтанд ихээхэн анхааралтай хандах хэрэгтэй”⁷ гэж бичсэнд тийм санаа илэрдэг.

В.фон Гумбольдт өөрийн олон бүтээлд хэл бол субъект, объект хоёрыг; мөн хүн, ертөнц, бурхан тэнгэр гурвыг шууд зуучлагч мөн гэж сурталчилдаг нь философидолтын уугуул орон зай бол сэтгэхүй биш, харин хэлний байгууламж (конструкци) мөн гэж тэрээр тайлбарладагтай нь уялддаг.

Танин мэдэхүйд хэлний гүйцэтгэдэг үүргийн тухай В.фон Гумбольдтын үзлээс түүхийн философид хамаарах нэг дүгнэлт гарах логик нөхцөл бүрддэг. Үүнд, түүхийн мэдлэг бол баримтыг сэтгэхүй, оюун ухаанаар яг зөв тайлбарлах бололцоо хязгаарлагдмал бөгөөд харин тэр (түүхийн мэдлэг) бол хэл, сэтгэхүй аль алины харилцан нөлөөллийн үр дүн мөн. Ийм учраас түүхийн мэдлэг бол ерөнхийг биш, харин бодгаль, нэгж зүйлийг, өөрөөр хэлбэл хэлний тухайн утгат зүйлийг илэрхийлдэг.

XX зууны эхний хагаст философийн бие даасан салбар болсон хэл шинжлэлийн (лингвистик) философийн олон томоохон төлөөлөгч В.фон Гумбольдтын ийм арга зүйн байр суурьт тодорхой засвар оруулж, шинжлэх ухааны танин мэдэхүй бол эцсийн эцэст хэлний, тэгэхдээ ерөөсөө хэлний биш, харин миний өөрийн хэлний үр дүн болж байдаг гэсэн үзлийг үндэслэн боловсруулжээ. Тухайлбал австрийн философич Л.Витгенштейн 1921 онд бичсэн “Логик, философийн шастир” гэдэг бүтээлдээ: “...бид сэтгэж болдоггүй юмыг сэтгэж чаддаггүй бөгөөд иймээс бид сэтгэж болдоггүй юмны тухай өгүүлж ч чаддаггүй”⁸ гэжээ. Энэ нотолгоо юмыг мэдрэгдэж (өөрөөр хэлбэл сонсдож, харагдаж, амтлагдаж) байвал л түүнийг байна гэж үзэх ёстой гэдэг Берклийн гносеологи солипсизмыг арай өөр төрлийн солипсизмоор, үүнд юмсын тухай мэдлэг бол үйлдэл, хэл хоёрын уялдааны үр дүн мөн гэж үзсэн байр сууринаас илэрхийлжээ. Үүнийг Л.Витгенштейний доорх нотолгоо улам тодорхой болгодог. Үүнд, тэрээр: “... чухамдаа солипсизмын ярьж байгаа зүйл тун зөв бөгөөд гагцхүү энэ нь өгүүлэгддэг бус, харин зөвхөн өөрөө илэрдэг юм.

Ертөнц бол миний ертөнц мөн гэдэг баримт нь хэлний (миний ойлгож буй ганц хэлний) хязгаар **миний** ертөнцийн хязгаар болдогт илэрнэ”⁹ гэж тэр бичжээ. Энд Л.Витгенштейн объектив ертөнцийг биш, харин судалгааны үр дүн болдог зүйлсийн (шинжлэх ухааны) ертөнцийг ярьж, ийм ертөнц төрөлхийн ба зохиомол хэлээр бий болон хадгалагдаж, илэрч байдгийг заажээ. Мөн энд ярьж буй

“миний” гэдэг тодотгол физик утгаар биш, харин праксеологи утгаар, үүнд ямар нэг хэмжээний хүрээ ба төвшний аль нэг байдлын үйлдэгч (субъект) гэсэн утгатай байдаг. Үүний нотолгоо нь Л.Витгенштейн: “Би” бол яг хүн биш, харин ертөнцийн хязгаар мөн. “...Философийн Би бол психологит ярьдаг хүн биш, хүний бие буюу хүний оюун биш зүйл бөгөөд метафизик субъект, хязгаар болохоос ертөнцийн хэсэг биш юм.”¹⁰ гэж бичсэн зүйл мөн. Л.Витгенштейн ийнхүү хүн оюун ухаан, шинжлэх ухааны судалгааны үр дүнгээрээ бүтээдэг мэт байдаг ертөнцийн дүр зураг бол хэрэг дээрээ хүн үйлдэлдээ хэрэглэж буй хэлээр, түүний бүтэц, онцлогоор тодорхойлогддог гэж үзжээ.


“Сэтгэж болдоггүй юмыг сэтгэж чаддаггүй” гэж Л.Витгенштейн бичсэн нь шинжлэх ухааны мэдлэг бол сэтгэхүйн үр дүн мөн гэсэн дүгнэлт рүү хүргэж болмоор байдаг. Гэвч тэрээр сэтгэхүй өөрөө эцсийн эцэст хэлээр тодорхойлогддог гэж үзсэнийг “(миний) хэлний хязгаар бол миний ертөнцийн хязгаар болдог” тухай өгүүлсэн түүний үг гэрчилдэг.

Л.Витгенштейний (эцсийн эцэст лингвистик шинжтэй) солипсизмыг үндэслэж буй хоёр чухал баримт дурдъя.

1. Л.Витгенштейн “Логик, философийн шастир”-таа оноосон нэрсийн утгат чанарыг авч үзээд: хэл бол баримтуудын “дүрийг” илэрхийлдэг гэсэн нь ийм үзлийн нэг жишээ мөн.

Гэхдээ Л.Витгенштейний ярьдаг “дүр” гэдэг ойлголт материалист тусгалын онолынхны “дүр” гэдэг ойлголт биш юм. Материалист тусгалын онолын үүднээс дүр бол дүрслэгдэгчийнхээ буюу тусгагдагчийнхаа агуулга, мөн чанарыг ямар нэг хэмжээгээр зөв илэрхийлдэг хуулбар мөн. Харин Л.Витгенштейнийхээр дүр бол өгүүлбэрийн хэсэг бүр нь “юмсын байрлалын” холбогдох хэсэгт тохирохуй мөн. Тэрээр “юмсын байрлал” хэмээсэн нь “баримтуудын бүтэц” гэсэн утгатайг, түүний хувьд баримт бол объектив юмс биш, харин эмпирик судалгааны объект ба үр дүн болсон зүйлс байдгийг тус тус энд харгалзах ёстой.

2. “Логик, философийн шастир” бүтээл бол эх хэлний үгийг хэрэглэх явцад утгын будилаан цөөнгүй гардгийг үндэс болгоод түүнийг (эх хэлийг) орлосон төгс (зохиомол) хэл бүтээх санаархал Л.Витгенштейн өвөрлөж байсан үеийн бүтээл мөн. Гэвч ямар ч төгс хэллэг, хэл бүтээлээ гэхэд тэр нь эх хэлний баялаг агуулгыг бүрэн илэрхийлж чадахгүйг Л.Витгенштейн сүүлдээ ойлгожээ. Тэгээд тэрээр ийм хожмын үедээ уг шинэ байр суурь, баримтлалаа илэрхийлсэн олон тэмдэглэл, ноорог бичсэн аж.. Тэдгээрээ Л.Витгенштейн эмхтгээд 1945 онд хэвлүүлэхэд бэлэн болгож, уг эмхтгэл нь түүнийг нас барснаас хойш (1953 онд) “Философи судалгаа” гэдэг нэртэй хэвлэгдсэн байна. Тэрээр “Философи судалгаа”-даа: хэлийг нэг мөр нарийн тодорхойлох аргагүй. Хэлний анхдагч элемент нь үг юм. Аливаа үгийг хэрэглэхэд тодорхой дүрэм шаардагдана. Иймээс хэл бол тодорхой дүрэм, горимын дагуу



явагдагч тоглоом лугаа ижил юм. Одоо байгаа тоо томшгүй тоглоом дээр шинэ шинэ тоглоом нэмэгдэн буй болох нь гарцаагүй. Үүнчлэн үгийг хэрэлэх янз байдалд тоо хязгаар байхгүй. Ийм олон янз дүрс тухайн үед тогтсон маягтай байна гэхийн аргагүй гэжээ.

Л.Витгенштейний "хэл бол тоглоом мөн" гэдэг томъёолол нь хэл, үйлдэл хоёр салшгүй холбоотой гэдэг урьдын (бихевиорист) үзэлд нь үндэслэж байдгийг судлаачид тогтоосон юм.

Хэлний философи баримтлалуудаас, тухайлбал "хэл бол тоглоом мөн" гэдэг үндэслэлээс түүхийг танин мэдэхүйд холбогдох арга зүйн дүгнэлт гарах үндэстэй байдаг. Тухайлбал: түүхийн мэдлэгийн агуулга бол субъектийн үйлдлээс, тэр нь хэлээ хэрхэн хэрэглэдгээс хамаардаг, өөрөөр хэлбэл уг мэдлэг субъектив агуулгатай байдаг; түүхийн мэдлэгт ерөнхий арга зүй байх бололцоогүй, харин тухайн мэдлэг бүрт өөрт нь тохирсон бодгаль арга байж болно; түүхийн мэдлэг аваас нийгмийн амьдралын үзэгдлүүдийн ерөнхийг, зүй тогтлыг үндэслэдэггүй, харин тэдгээрийн төсөөг бол илэрхийлэх бололцоотой гэх мэт юм.

Философийн структурализм ба түүхийг танин мэдэхүй.

Хэлийг зөвхөн эх хэл гэж хязгаарлалгүйгээр харин утга илэрхийлж чадах аливаа тогтолцоо мөн гэж ойлгон тайлбарлаж, үүнийхээ үндсэн дээр түүхийн тодорхой үзэгдлүүдийг онцгой маягийн жич жич хэл мөн гэж үзээд, тэдгээрийн утгыг нээн тайлбарлах замаар түүхийн мэдлэг гаргаж авдаг философи арга зүй XX зууны 50-60-аад онуудад бий болсон билээ. Тэр аргыг "структурализм" гэж нэрлэдэг болсон юм. Уг аргыг боловсруулсан гол төлөөлөгч нь К.Леви-Стросс мөн.

Түүхийг танин мэдэхүйд зөвхөн рационализмыг баримтлахаас татгалзсан байр суурь К.Леви-Строссын структурализмд илэрдэг гэж болно. Түүний үзлээр эрүүл ба өвчтэй, орчин үеийн ба эртний хүй нэгдлийн зэрэг аливаа хүний ухамсрын гүнд ухамсаргүй сэтгэлийн бүтцүүдийн цогц байдаг. Ухамсарт мэдлэг бол бодит баримтанд түшиглэхийн оронд тухайн баримтыг аль нэг схемд зориулан сонгодог. Харин ухамсаргүй сэтгэл бол объектив шинжтэй байж, улмаар ухамсрыг тодорхойлж байдаг.

К.Леви-Стросс ийм философи баримтлалаасаа: түүхийн мэдлэг бол баримтыг гуйвуулсан байдаг бөгөөд харин бүтэц бол түүхээс илүү объектив байдаг гэсэн өөр нэг баримтлал гаргаж иржээ. Энэ нь ухамсаргүй сэтгэл бол өвөрмөц хэлээр илэрдэг тухай түүний тайлбартай уялддаг. Үүнд, К.Леви-Строссынхоор ухамсаргүй сэтгэлийг илэрхийлдэг хэл маш олон хэв маягтай байдаг. Тухайлбал эртний овгуудын гэрлэх ёс журам, зан үйл, янз бүрийн өмсгөл, баг, миф (шидэт домог), үлгэр зэрэг бол тус бүртээ хэлний үүрэг гүйцэтгэж чаддаг. Эдгээр тус тус хэлийг агуулгынх нь үүднээс ойлгож, харилцан бие биед нь шилжүүлж, нэгий нь бусдаар нь орлуулах байдал бол ухамсаргүй сэтгэлийг буюу объектив психик бүтцийг нээж, улмаар ухамсаргүй сэтгэлийг ухамсарт мэдлэг рүү

хөрвүүлж, дотоод ухамсрыг нээх бололцоо олгоно гэж К.Леви-Стросс үзсэн юм.

Тэрээр дотоод ухамсар, ухамсаргүй сэтгэл хоёрыг тухайн үеийнхээ психолологид ярьдгаас илүү тодорхой агуулгатай болгон тайлбарласан байна. Тухайлбал австрийн философич, сэтгэл судлаач З.Фрейдийн (1856-1939) тайлбараар дотоод ухамсар бол хүний балчир бага насанд ухамсарт нь бий болоод аажимдаа цаад гүн давхраа болон далдлагдсан зүйл байдаг билээ. К.Леви-Строссын хувьд дотоод ухамсар бол "...бодгаль бүхэн амьдралынхаа туршид хуримтлуулдаг янз бүрийн дурдатгал, дүр зэргийн сан.., бидний тус тусын бодгаль чанарын түүхэнд хамаарах үгийн санг тэмдэглэдэг бодгаль толь бичиг"¹¹, өөрөөр хэлбэл ой дурсамжийн нэг тал мөн. Харин ухамсаргүй сэтгэл бол "энэхүү толь бичгийг өөрийн хуулиудын дагуу зохион байгуулан утгат чанартай болгож, улмаар бидэнд өөрт болон бусад хүмүүст (тэгээд бас ухамсаргүй сэтгэлийн хуулиудын дагуу түүний хэрхэн зохион байгуулагдсны нь хэр хэмжээгээр) ойлгомжтой хэл бүтээдэг".¹²

К.Леви-Стросс ийм үзлийнхээ үүднээс дүгнэхдээ: түүхийн мэдлэг зөвхөн ухамсарт мэдлэг байх аваас тэр нь субъектив, гуйвуулгатай байх болно. Харин янз бүрийн миф, баг, өмсгөл зэрэг соёлын аливаа материалыг эх хэлэн дээр тогтдог онцгой хэл байдалт нийлмэл зохион байгуулалтат тэмдгийн тогтолцоо, өөрөөр хэлбэл ухамсаргүй сэтгэлийн хэл мөн гэж үзээд түүний утгыг зөв тайлбарладаг байвал уг тайлбар нь түүхийн үнэн мэдлэг байх болно гэсэн юм. Хүй нэгдлийн үеийн "зэрлэг сэтгэхүйн" чухал онцлогууд бол уламжлалт нийгмүүдийн оюуны төрхөд төдийгүй орчин үеийн сэтгэхүйн эд эсэнд шинжлэх ухааны сэтгэлгээний хэлбэрүүдтэй зэрэгцэн байж шууд чаддаг гэж К.Леви-Стросс үзсэн байна.

Гэхдээ энэ бол эртний мифологи сэтгэхүй, орчин үеийн логик сэтгэхүй хоёр юуг логик оюун дүгнэлтийн үндэслэгээ болгодгоороо бие биеэсээ ялгаатай байдгийг үгүйсгэхэд хүргэх ёсгүй гэж К.Леви-Стросс тайлбарладаг. Түүний бичсэнээр мифологи сэтгэхүй дэх дүгнэлт гаргах үндэслэгээ нь орчин үеийн хүний сэтгэхүйн үүднээс авч үзвэл хангалттай биш, гол биш, тохиолдлын шинжтэй нь элбэг байдаг аж. Тийм учраас мифологи сэтгэхүйн логикт нь зууч шаардагддаг хэмээн К.Леви-Стросс дүгнэн дурдсан юм. Тэр зууч зүйлээ "бриколлаг" гэдэг франц гаралтай үгээр тэрээр нэрлэдэг. Бриколлаг бол тодорхой зүйлд тухайн нутаг, овгийнхон анхаарлаа хандуулдаг байдал нь бэлгэдлийг (символыг) ашиглахтай уялддагийг заадаг. Бэлгэдэл бол мэдрэхүйн тодорхой дүр, хийсвэр ойлголт хоёрын дундах завсрын логик байдал(статус) болж өгч байдаг. Ийнхүү аливаа бэлгэдэл бол сэтгэхүйн тодорхой нэгжийн буюу завсрын үүрэгтэй байдаг. Улмаар тодорхой бүлэг бэлгэдэл дэх утгын талбаруудыг нэгтгэн холбодог кодууд нь мифологи сэтгэхүйн категориудын үүрэг гүйцэтгэдэг гэж К.Леви-Стросс нотлон бичсэн байна.

Ийнхүү К.Леви-Строссын боловсруулсан түүхийн тухай философи үзэлд дараахь зарим онцлог байдаг. Үүнд, тэрээр:

-хүн төрөлхтний түүхийг бүхэлд нь биш, харин зөвхөн тодорхой үеийг нь (К.Леви-Строссын хувьд эртний овгийн харилцааны үеийнхий нь) онцолж судалдаг;

-ингэхдээ эртний зарим овгийн соёлын амьдралын материалуудыг болон XX зуунд овгийн харилцаанаас хараахан ангижраагүй байгаа зарим ард түмний амьдралын хэв маягийг түүхэн судалгааныхаа объект болгон, уг судалгааныхаа үр дүнг эртний ард түмнүүдийн амьдралын загвар болгосон; өөрөөр хэлбэл түүхийн үзэгдлүүдийн зүй тогтолт холбоог биш, харин төсөөг илрүүлэх бололцоотой гэж үзсэн;

-судалгааныхаа объектийг тэмдгийн тогтолцоо буюу тодорхой хэл гэж үзэж, энд тэмдэглэгдэгч нь тэмдэглэгчтэйгээ харьцуулахад ямагт тодорхойлогч, нөхцөлдүүлэгч шинжтэй байж, гэхдээ тэмдэглэгдэгч, тэмдэглэгч хоёрт уг чанарын холбоо байдаггүй хэмээн хандсан зэрэг юм.

Бүтэцчилэн судлах аргыг түүхийн судалгаанд онцлон хэрэглэсэн хоёр дахь томоохон онолч нь францын философич М.Фуко юм. Тэрээр 1950-иад онуудын дунд үеэс хойш туурвин бүтээх ажлыг тасралтгүй эрчимтэй хийж иржээ. Улмаар 1960-аад онуудад бичсэн бүтээлүүддээ структуралист хандлагыг нэлээд тогтон баримталжээ. Тухайлбал 1963 онд хэвлүүлсэн "Эмнэлгийн газрын үүсэл. Эмчийн үзлийн археологи" гэдэг номондоо XVIII зуун ба XIX зууны эхэн үеийн анагаах ухааны мэдлэг, түүнд үндэслэсэн практикийн тухай тэр үеийнхний нь нийтлүүлсэн зүйлсийг судлаад рационализмыг тодорхой хүрээнд зөвшөөрөх ёстойг структуралист зарчмын үүднээс үндэслэсэн байдаг. Тэгээд структуралист зарчимд нийцсэн дараахь хэдэн рационалист дүгнэлтийг тэрхүү онцлон авч үзсэн үедээ холбогдуулж хийсэн байдаг. Үүнд:

-Дурьдан буй үеүдэд өвчтөнөөс урьд өвчнийг объектив төлөв байдлаар авч үздэг болж, түүнийг холбогдох аливаа хүнд хамааруулдаг болсон;

-Өвчтөнийн бие бол зөвхөн физик, биологи зүйл биш, харин хүний бие, нийгмийн практик хоёрын харилцан нөхцөлдөл мөн гэж үзэх болсон;

-Биенд нуугдмал өвчнийг янз бүрийн шинж тэмдэг (симптом) илчилдгээс гадна эмнэлгийн шинжилгээ илрүүлдэг;

-Өвчнийг хүн, цогцос аль алин дээр судалж болдог бөгөөд эдгээр судалгаа бие биеэ нөхдөг.

М.Фукогийн "Эмнэлгийн газрын үүсэл..." гэдэг бүтээл бол түүний бичсэн археологийн гурамсан бүтээлийн анхных нь мөн. Тэрээр "археологи" гэдэг нэр томъёог ерөнхийдөө "зарчмын тухай сургаал" гэсэн утгаар хэрэглэж, улмаар хүн төрөлхтний сэтгэлгээний тодорхой тодорхой хэв маягийг түүхчлэн авч үздэг аргаа "мэдлэгийн археологи" гэж нэрлэсэн юм. Энэ аргын үүднээс хандвал хүн

төрөлхтний сэтгэлгээ урагшлан дэвшиж хувьсдаг биш, түүхийнхээ өмнөх шатуудтай уламжлалт холбоотой байдаг биш, харин тэр нь үсрэлт, дэлбэрэлт байдлаар өөрчлөгдөж байдаг (М.Фуко "мэдлэгийн археологи" гэдэг аргаа 1970-аад онуудад буюу постструктуралист баримтлалууд бий болгосон үедээ улам цэгцлэн боловсруулжээ). Иймээс тэрээр танин мэдэхүйн төлөв, өвчтөн ба эмчилгээ, хүмүүс солиорол гэж юуг ойлгодог, мөн тэдний бэлгийн мэдрэмж ямар байдаг зэрэг асуудлыг ерөнхий, хавтгайруулсан онолын үүднээс биш, харин түүхэн тодорхой орон зай, цаг хугацааны хүрээнд нь, зөвхөн тэр нөхцөлд холбогдох дүгнэлт хийх зорилгоор судалж иржээ.

Мэдлэгийн археологийнхоо зарчмын үүднээс М.Фукогийн бичсэн хоёр дахь томоохон бүтээл нь 1966 онд хэвлүүлсэн "Үг ба юм. Хүмүүнлэгийн ухааны археологи" ном ажээ. Энэ номон дахь түүхийг танин мэдэхүйд арга зүйн ач холбогдолтой нэг чухал үндэслэлийг онцлон дурдъя.

"Үг ба юм..." зохиолдоо М.Фукогийн бичсэнээр танин мэдэхүйн зүйлсийн ахуйн үндсэн арга нь XVII-XVIII зуунд адилсал, ялгаа хоёрыг дэг журамтай болгодог орон зай байсан бол XIX зуунаас хойш цаг хугацаа болж хувиран, энэ нь түүхийн тухай тогтон ярихад хүргэдэг болж байна. Тухайлбал орчин үеийн шинжлэх ухаанууд үүссэн шалтгааныг судалж үзэхэд илэрч буй нэг чухал зүйл гэвэл амьдрал, хөдөлмөр, хэл гурав сэтгэхүйн логик хуулиудтай адилгүй хуулиудын дагуу дотоод хүчээрээ, дотоод ахуйгаараа бий болжээ. Үүний үр дүнд баялгийн сонгодог арилжааны оронд эдийн засгийн үйлдвэрлэл болох хөдөлмөр бий болов. XVII-XVIII зууны байгаль ёсны түүхэн дэх адил юм уу ялгаатайн гадаад шинжүүдийг ангилдаг логик үйлдлийн оронд XIX зуунаас эхлэн "амьдрал" гэдэг нууцлаг үзэгдлийг судлах болсон. Ингэхэд сонгодог буюу XVII, XVIII зууны сэтгэлгээнд танин мэдэхүйн объектуудыг эрдэс бодис, ургамал, амьтан гэж бүлэглэдэг байсны оронд органик ба органик биш, амьд ба амьгүй гэсэн эсрэг хосуудыг авч үздэг болж, улмаар орчин үеийн биологи үүсчээ. Сонгодог буюу XVII, XVIII зууны сэтгэлгээнд нэрийн тухай онол ноёрхож, үгийн анхдагч үндэс, анхдагч утга хоёрын нэгдлийг онцолдог байсан бол орчин үеийн хэлний судалгаанд флексийн онол ноёрхов. Энд төлөөлөл, сэтгэхүй хоёрын ямар ч универсаль хуулинд хүргэдэггүй тийм грамматик хуулиудын систем бүхий янз бүрийн хэлний амьд цогцыг судлахыг чухалчлах болжээ.

Тэгээд М.Фуко: "...хөдөлмөр, амьдрал, хэл гурав тийнхүү амьд биес, үйлдвэрлэлийн хуулиуд, хэлний хэлбэрүүдийг объектив байдлаар танин мэдэх бололцоо олгодог "трансценденталь" болж илэрдэг. Эдгээр нь ахуйнхаа хувьд ухамсрын гадна оршиж, ингэснээрээ танин мэдэхүйн нөхцөл болдог"¹³ гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Түүхийг танин мэдэхүйд энэ дүгнэлт арга зүйн ямар утга учир бүхийг нь мэдлэгийн археологи зарчимтай холбон илэрхийлэхэд түүхийн судалгааны үр дүн бол ухамсрын тодорхой

бүтээл мөний хувьд өөрөөсөө гадна оршигч түүхийн баримтыг (үнэнээр, алдаж, зориуд гуйвуулж гэх мэт) хэрхэн илэрхийлэх нь цаг хугацааны хүчин зүйлээс хамаарч байдаг.

М.Фуко "мэдлэгийн археологи" нэртэй структуралист зарчмаа 1969 онд хэвлүүлсэн "Мэдлэгийн археологи" зохиолдооо хамгийн тод хэрэглэсэн юм. Гэхдээ энэ зохиол бүтцийн анализыг бүхнээс дээдлээгүй бөгөөд ер нь дан ганц бүтэцчилэх зарчмын хүрээнд бүтээгүй хэмээн М.Фуко өөрөө өгүүлсэн билээ.

Миний энэ өгүүлэлд М.Фукогийн уг зохиолын агуулгыг бүхэлд нь илэрхийлэх гэлгүйгээр гагцхүү түүхийн философид холбогдох зарим гол үндэслэлийг нь товч дурдах юм.

Түүх бол болсон үйл явдлыг яг байгаагаар нь илэрхийлсэн мэдлэг мөн гэдэг санаа М.Фукогийн бүтээлүүдэд дайралддаггүй юм. Тухайлбал "Мэдлэгийн археологи" зохиолдоо: түүх бол үзэл санаа, шинжлэх ухаан, философи сэтгэлгээ, утга зохиол зэргийн түүх мөн гэж М.Фуко үзжээ. Тэгээд уламжлалт түүхэн дэх сэтгэлгээний нэн чухал ойлголтууд болох үл тасалдал, оюуны ба ухамсрын бүхэллэг ба нэг утгат илрэл, улмаар "эрин", "зуун" гэх мэт том том нийтлэг зэргийн оронд орчин үеийн түүх аваас тасралтын гоц үзэгдлүүдийг (феноменүүдийг) авч үзэх боллоо гэж тэрээр сурталчилсан юм. "Мэдлэгийн археологи" зохиолд төдийгүй түүнээс хойшхи М.Фукогийн зарим бүтээлд түүх бол тасралтат шинжтэй гэдэг баримтлалыг боловсруулжээ. Энэ баримтлалд түүх бол нийгэм, эдийн засгийн трансформациар нөхцөлдсөний үндсэн дээр нийгмийн организм хувьсаж буй үйл явц мөн гэж үзэхийн үл зөвшөөрдөг. Тэгээд: түүх бол түүхэн дэх тасралтгүй шинжийн тасалдлыг ойлгохуй, иймд зүй тогтол, түгээмэл зүйл, тогтворт нийтлэг байхгүй нь ажиглагч хүнд ойлгогдохуй мөн гэдэг. Ийнхүү М.Фукогийн хувьд түүх бол хүмүүнлэгийн ухаан мөний хувьд ухамсаргүй үйлдлийн хүрээ, "ухамсарт биш завсрын текст" юм.

Түүхийн тухай ийм үзэл марксизм, позитивизм, ер нь түүхийн философийн өөр олон сургаалын арга зүйн баримтлалыг сөрөн бий болжээ. М.Фуко түгээмэл дүрмийг биш, харин тохиолдлыг; гүнийг биш, харин гадаргыг; нэгдлийг биш, харин олонлогийг; үндэслэгээг биш, харин өө сэвийг; адилыг биш, харин ялгааг чухалчлан өгүүлсэн байдаг. Түүний үзлээр "уламжлалт түүх аваас баримт, үйл явдал хоёрын хоорон дахь (энгийн шалтгаал, орчилт шинж, антагонизм зэргийн болон бусад зүйлийн) харилцааг тодорхойлохыг зорилтоо гэж үздэг. Энэ бол аль хэдийн бүрэлдэн тогтсон эгнээнүүд дэх элементүүдийн байр суурийг тодотгох гэдэг яриа байлаа. Өнөөдөр эгнээнүүдийг тогтоох ба дахин тогтооход, эгнээний элементүүдийг тодорхойлоход тухайн тохиолдол бүр дэх янз бүрийн харилцааг нарийн зааглахад, хуулийг гаргаж авахад болон эдгээр маягийн бусад бүхнээс гадна янз бүрийн эгнээ ба дэс дарааллын хоорондын холбоонуудыг тэдгээрийн "матрицыг" нь тогтоох зорилгоор тоочин илэрхийлэхэд асуудал оршдог"¹⁴. Ийм учраас орчин үеийн буюу

шинэ түүх аваас янз бүрийн үйл явдлын чухал эсэхийг, тэдгээрийн ямар ямар хэв маяг, төвшин буйг ялган тогтоох ёстой. Тийнхүү “үйл явдлыг үргэлжлэх хугацаагаар нь бага, дунд, (жишээ нь, техникийн ололтын нэвтрэлт ба мөнгөний дутагдал), эцэст нь их (хүн ам зүйн тэнцвэр, цаг уурын өөрчлөлтөнд эдийн засаг улам бүр идэвхитэй оролцох байдал) хэмээн ярьж болно. Ховор юм уу эсвэл үүний эсрэг давтагдагч үйл явдлуудаар бүрдсэн эгнээнүүдийг ялган үзэх ёстой нь бас эндээс гарч ирдэг. Орчин үеийн шинжлэх ухааны хүлээж авсан “их үргэлжилдэг үе” гэдэг ойлголт бол түүхийн философи руу, дэлхийн их эринүүдийн тухай ойлгоц руу, “иргэншлүүдийн зориулалтаас” гаралтай мэт үечлэлүүд рүү буцаж очих тухайг гэрчилдэг биш ээ. Энэ бол эгнээнүүдийг тогтоох процедурын арга зүйн үр дүн төдий мөн. Гэвч үзэл санаа, шинжлэх ухаан, сэтгэлгээний түүхэнд тийм төрлийн өөрчлөлтүүд огт өөр үр дагаварт хүргэдэг. Үүнд: тэдгээр нь ухамсрын ба оюун ухааны дэвшил, хүн төрөлхтний сэтгэлгээний хувьсал зэргийн үр дүнд бий болдог урт урт гинжийг тасдаж, зохицол ба төгөлдөржилтийн үзэгдлийг болон мөн түүнчлэн нэгтгэн дүгнэх бололцоог өөрийг нь эргэлзээтэй болгодог. Тэдгээр янз бүрийн эгнээ ба дэс дарааллыг, үүнд хоорондынх нь (оногдуулга, харилцан таараа, харилцан нөхөлт, харилцан огтлолцол) харилцан үйлдэл энгийн шугаман схем рүү хүргэдэггүй. Тийм янз бүрийн эгнээ ба дэс дараалалыг бодгальчилж байдаг”¹⁵.

Сонгодог түүхийн хувьд тасралтат шинж бол хааш яйш (шийдвэр, тохиолдол, санаачлага, нээлт зэрэг) үйл явдлын явцад илэрдэг тохиолдолт зүйл, үүнд үйл явдлын тасралтгүй цуваагаар зүй ёсоор арчигдах ёстой тийм зүйл мөн. Ийнхүү энд тасралтат шинж бол түр задрал, үүнд түүхээс зувчуулсан задрал мөн.

Харин орчин үеийн түүхэнд тасралтат шинж аваас түүхэн анализын нэг үндсэн элемент болж, гурван үндсэн үүрэг гүйцэтгэдэг боллоо гэж М.Фуко үзсэн байна. Үүнд: нэгдүгээрт, тасралтат шинж аваас түүхч хүн материалаасаа гаргаж авсан зүйлийг биш, харин тэр хүний зориудын үйлдлүүдийг тодорхойлдог. Учир нь, түүхч хүн нэлээд магадлалт төвшинд боловч анализын бололцоот төвшингүүд, тэдгээр төвшин тус бүрт нь тохирсон арга, чухал чухал үечлэлийг илрүүлдэг. Хоёрдугаарт, тасралтат шинж бол анализын тусламжтайгаар үгүйсгэх ёстой зүйл биш, харин аль нэг үйл явцын зааг, янз бүрийн хугарлын цэг, юмсын ердийн явцын зөрчигдөл, хэлбэлзлийн зөрүү, оршихуйн босго, шалтгаан үр дагаврын холбооны тасалдал зэргийг зорилтондоо багтаадаг тийм өөрийгөө тоочин илэрхийлэхүй мөн. Гуравдугаарт, тасралтат шинж бол эрдэмтэн хүн шинэ өвөрмөц онцлогийн цэсийг үл тоомсорлох, тасалдлыг позитив (эерэг) хоёр фигурын (хэлбэрийн) дундах ан завсар гэж үзэх зэрэг байдал гаргалгүйгээр харин улам шинэ шинэ өвөрмөц онцлогийн цэсийг илэрхийлдэг концепт мөн.

Ийнхүү М.Фукогийн үзлээр түүхийг танин мэдэхүйд тасралтат шинж бол судалгааны объект ч, бас арга, хэрэгсэл ч болж байдаг.

Түүний анзаарснаар тасралтат шинжийн ойлголтыг өөр өөрийн онцлогтойгоор бүрхэгдүүлдэг олон ойлголт байдаг¹⁶. Тэдгээр ойлголт чанд баримтлалын бүтэцгүй боловч өөр өөрийн тодорхой үйл (функци) бүхий байдаг. Нэн түрүүнд “уламжлал” гэдэг ойлголтыг М.Фуко энд жишээ болгосон. Үүнд, түүний тайлбараар уламжлал бол гоц үзэгдлүүдийн (феноменүүдийн) дэс дараалалтай, адилхан (дор хаяж төсөөтэй) цогцод цаг хугацааны онцолсон байдлыг мэдээлэхүй мөн. Уламжлал бол түүхийн сарнилыг нэгтгэж нэг хэлбэрээр ухаарах бололцоо олгодог. Тэр нь бас үл тасалдалт шинжийг алгасах үндсэн дээр эх сурвалжийн төгсгөлгүй тодорхойлолтонд хүрэхийн тулд эхлэлүүдийн ялгааг зөөлрүүлдэг. Бид уламжлалын ачаар үл өөрчлөгдөгчийг үндэслэгээ болгоод шинийг ялгаж онцлох, мөн шинэлэг зүйлсийг тухайн бодгалийн зориудын сонголт, суу билиг, өвөрмөц шинж гэж тайлбарлах бололцоотой болдог.

“Нөлөө” гэдэг ойлголтыг М.Фуко шүүмжилжээ. Түүний тайлбараар нөлөө бол шилжүүлэх, хамааралд байх үйл явцад хэрэгждэг. Ийм үйл явдал ээлжиндээ шалтгагчдын талбар луу, төсөө давталт хоёр өөрсдийн хамгийн тохиромжтой орчин болох орон зай, цаг хугацаа хоёроор дамжиж байж бодгаль хүмүүс, зохиол, ойлголт, онол гэх мэт олон нэгдлийг холбодог тэр талбар луу хүргэдэг.

“Хөгжил”, “хувьсал (эволюци)” гэдэг хоёр ойлголтыг арга зүйн хувьд нэг зиндаанд М.Фуко тавьжээ. Үүнд, энэ хоёр ойлголт сарнисан үйл явдлуудын дэс дарааг шинээр бүлэглэх, тэдгээр үйл явдлыг зохион байгуулалтын нэгдмэл зарчмаар холбож, амьдралын жишээний (тэдгээр үйл явдлын зохицол, шинийг нэвтрүүлэх бололцоо, янз бүрийн элементийнх нь үргэлжилсэн тохироо бүхий) хүчинд захируулах бололцоо бүрдүүлдэг. Энэ хоёр ойлголт аливаа эхлэл дэх холбоо хэлхээний зарчмыг илрүүлж, ирээдүйн нэгдлийг томъёолоход хэрэг болдог.

Постструктурализм ба түүхийг танин мэдэхүй.

Структурализмыг дотроос нь болон гаднаас арга зүйн үүднээс нь шүүмжлэх байдал түүний бий болсон анхны үеэс гарч иржээ. Тухайлбал дотроос нь шүүмжлэгч нар структурализмын дараахь үндэслэлүүдийг шүүмжлэх замаар постструктурализмд шилжсэн байна. Үүнд, нэгдүгээрт, бүтэцчилэх баримтлал судалгааны түгээмэл зарчим байх үндэсгүй бөгөөд учир нь, судалгааны олон тооны үзэгдэл, үйл явдал бүтцээс гадуур байдаг гэдэг үндэслэл бий болсон. Хоёрдугаарт, тэмдгийн тогтолцоонд тэмдэглэгдэгчээсээ тэмдэглэгч нь хамаардаг тухай структуралист үзэл худлаа бөгөөд угтаа тэмдэглэгч нь тэмдэглэгдэгчийн оршихуйг хариуцдаг гэдэг дүгнэлтэнд хүрсэн. Гуравдугаарт, структурализмын үндсэндээ рациональ (оюун ухааныг чухалчлах) өнгө аяс нь бие даасан байдлаараа түүх, соёлын судалгаанд сэтгэл ханахаар амжилт гаргаж чадахгүй байгааг анзаарсан зэрэг юм.

Постструктурализмын үндэслэлүүдээс түүхийг танин мэдэхүйн арга зүйд гарцаагүй харгалзах ёстой тийм хэсгийг нь онцлон дурдъя. Үүнд:

-Тэмдгийн бүтцийг репрезентацийн (төлөөллийн) тухай онолын үүднээс тайлбарлавал тэмдэг бол тэмдэглэгч, тэмдэглэгдэгч, мэдээлэгч (жишээ нь эх хэлэнд бичгийн ба ярианы үг, түүний утга агуулга буюу концепт, бодит юм үзэгдэл) гурваас тогтдог. Харин ийм үзлийг анх Ж.Деррида өөрчилж, тэмдэг бол бодит байдлыг төлөөлдөг биш, харин ямагт өөрийгөө давтаж, тохиолдол бүхэндээ өөрөөсөө ялгаатай болж байдаг гэсэн юм.

Тэмдгийн бүтцийн тухай репрезентатив тайлбарт Ж.Делёз бас нэмэлт, засвар оруулжээ. Үүнд, түүнийхээр тэмдэг бол илрэл, десигнаци, сигнификаци, утга хэмээх дөрвөн элементтэй.

Ж.Дерридагийн үзлийг гүнзгийрүүлэн тодотгосон Ж.Делёзийн ийм тайлбар нь: тэмдгийн утга бол объектив агуулгатай байдаг биш, харин түүнийг (тэмдгийг) субъект хэрхэн хэрэглэж буй байдлаар тодорхойлогддог гэдэг биевиорист хэл шинжлэлийн философийн арга зүйг гарцаагүй санагдуулдаг.

-Постструктурализмын үүднээс тэмдэглэгч бол тэмдэглэгдэгчид хамаарахгүйгээр зөвхөн тэмдэглэгчээрээ "хөвж", өөр хоорондоо харилцан үйлдэл хийдэг. Ийм учраас тайлбар (интерпретаци) бол утгын илрэл биш, харин тэмдэглэгч үйл явц болох ухамсаргүй сэтгэлийн ажилбарыг мэдрэхүй мөн (Ж.Лакан).

-Тэмдгийн хамгийн чухал төрөл болох амьд хэлийг (амьд яриаг) бичигтэй ямар харьцаа бүхий вэ гэдгийг Ф.де.Соссюр зэрэг хэл шинжлэлийн гарамгай төлөөлөгчид шийдвэрлэхдээ: бичиг бол яриатай (хэлтэй) харьцуулахад хоёрдогч шинжтэй, иймд бичгийн яриаг бодвол аман яриа үнэнд илүү ойр байдаг гэснийг Ж.Деррида үл зөвшөөрчээ. Тэрээр: бичгийн яриа бол аман ярианаас давуу. Учир нь, ярианы аман хэлбэр бол амьд хэл, үүнд энэ хэлийг бичиглэн тэмдэглэсэн (график)тогтолцооноос илүүтэйгээр бодит байдалтай холбогддог тийм хэл мөн. Аливаа хэлний үг бүрийг кирилл, латин зэрэг өөр өөр үсгээр, дүрс үсгээр, авианы өөр өөр галигаар илэрхийлж болдог. Гэтэл бичиг буюу бичгийн тогтолцооны тэмдэглэх (нөхцөлт) шинж бол уг системийн онцлогоос, түүний түүхэн төлвөөс болон уламжлалт, хадгалагдах шинжээс ихээхэн хамаардаг гэж тайлбарладаг. Тэрээр энэ санаагаа бүр хожмын бүтээлүүддээ ч гэсэн илэрхийлж: "бичиг бол утгат чанар олсон зүйлийн сав мөн" гэсэн байдаг¹⁷. Ийнхүү Ж.Деррида аман яриа бол сэтгэхүйтэй, өөрийгөө ухамсарлахуйтай шууд холбогдож, утгыг үзэмжээрээ тогтоож байдгаараа бичгийн яриатай адил, иймд ярианы энэ хоёр хэв маяг аль аль нь тэмдэглэгдэгч бодит байдлыг үнэн илэрхийлэх бололцоо хязгаарлагдмал гэж үзжээ. Үүний зэрэгцээ бичиг бол шинжлэх ухаан тус бүрийн нэр томъёо, хэллэг, хэм хэмжээг бататгаж байдгаараа аман ярианаас давуу гэж тэрээр үздэг аж. Ж.Дерридагийн хувьд хэлний аливаа хэв маяг бол сэтгэхүйг

илэрхийлдэг хэрэгсэл биш, харин бодгаль хүмүүсийн хамаарлын хэрэгсэл, "санаа бодлын ойлгоц" мөн.

-Тэмдэглэгчийн нэг онцгой төрөл нь символ (бэлгэдэл) мөн. Тэр нь өөрийгөө биш, харин нийгмийн хүчин зүйлийг тэмдэглэдэг. Тиймээс бэлгэдэл бол, ер нь аливаа тэмдэглэгч бол юмны эзэнгүйг далимдуулагч ирэхүй, тухайн юмыг хангалттай бишээр орлохуй болж байдаг (Ж.Лакан);

Тэмдэг, түүний бүтцийн элемент бүрийн, мөн түүний өөр өөр хэв маяг тус бүрийн үйлийн (функцийн) тухай постструктуралист үндэслэлүүд нь тэдний түүх, нийгмийн сэтгэлгээнд арга зүйн чухал ач холбогдолтой байдаг. Тухайлбал постструктуралистууд аливаа мэдлэг баттай үнэн байж чаддаггүй гэсэн дүгнэлт хийсэн юм. Тийм аваас мэдлэгийн үнэлэмж юугаар тодорхойлогддог вэ? гэдэг асуулт гарах үндэстэй. Ийм асуултанд хариу болох зүйлийг постструктуралистууд өгүүлдэг. Энд М.Фукогийн өгүүлснийг жишээ болгон дурдъя.

М.Фукогийн тайлбараар мэдлэгийн үнэлэмж нь үнэн юм уу худлаагаар биш, харин эрх мэдлээр тодорхойлогддог. Ингэхдээ тэрээр эрх мэдлийг танин мэдэхүйн, нэн түрүүнд шинжлэх ухааны хүрээнд авч үзсэн байна. Түүний хувьд эрх мэдэл бол хүний ухамсарт шинжлэх ухааны янз бүрийн дискурс (уялдмал хэллэг) ноёлдог байдал мөн. Тодруулан хэлбэл шинжлэх ухаанаар олж авсан мэдлэг угтаа харьцангуй байдаг тул тэр нь "түгээмэл үнэн байдаг" тухай үзлийн үүднээс бол эргэлзээтэй. Гэхдээ шинжлэх ухааны мэдлэг хүний ухамсарт "эргэлзээгүй нэр хүнд" болж өгөгдөн, өөрийгөө бэлэн зэлэн янз бүрийн ойлголт, мэдлэгийн цогц гэж үзэхийг тулгадаг хэмээн М.Фуко тайлбарлажээ.

М.Фуко мэдлэг бол эрх мэдлээр тодорхойлогддог гэж анх үзэхдээ тийм байдлыг зөвтгөх зорилго тавиагүй ажээ. Мэдлэгийг агуулгын хувьд тэнэглэл хэмээн тэр үедээ тэрээр үнэлсэн нь ийм байр суурийн чухал эпистемологи гэрч мөн. Түүнээс гадна тэрээр ийм байр сууриа ёс суртахууны үүднээс илэрхийлсэн аж. Үүнд, аливаа мэдлэг бол шударга биш байдалд үндэслэдэг хэмээн М.Фуко үзсэн байна. Өөрөөр хэлбэл танин мэдэхүйн үйлдэлд нь хүртэл үнэн байх, үнэнийг үндэслэх эрх байхгүй бөгөөд мэдлэгийн төлөөх инстинкт өөрөө хорлонтой (заримдаа хүн төрөлхтний аз жаргалыг шууд бусниулдаг) гэж тэрээр үзжээ. Ийм үзэл бол нэн түрүүнд шинжлэх ухаан-техникийн дэвшлийг Ф.Ницшегийн нөлөөгөөр "мэдлэгийн төлөөх хүсэл эрмэлзэл" гэж зарлан, түүний нэр хүндийг иррационалист байрнаас үгүйсгэдэг байдал мөн гэж судлаачид дүгнэн бичсэн байдаг.

Харин М.Фуко хожмоо эрх мэдлийн эерэг ач холбогдлын тухай бичих болсон. Үүнд, субъект эрх мэдлийнхээ тусламжтайгаар эрх чөлөө олох бололцооны тухай өгүүлдэг болсон аж.

Гэхдээ эрх мэдэл эерэг, сөрөг аль ч үйл бүхий байсан тэр нь мэдлэгийн байнгын бөгөөд гарцаагүй гол нөхцөл байдлаар

М.Фукогийн сургаалд яригддаг. Ийнхүү түүний үзлээр эрх мэдэл бол танин мэдэхүйн үр дүнг фаталистаар тодорхойлж байдаг.

Эрх мэдэл эерэг, сөрөг ямар ч үйл түүхэнд гүйцэтгэлээ гэсэн тэр нь М.Фукогийн философид бүтэцлэг биш байдаг. Учир нь, эрх мэдэл ямар ч нөхцөлд илэрсэн ямагт дарамтлагч, тасалдалт, зөрчилт, бүхэнд хүртээлтэй, гарцаагүй зэрэг олон иррациональ шинжтэй. Иймд тэр нь дэг журамтай, объектив, тогтвортой, зайлшгүй элементүүдтэй зэрэг бүтэцлэг шинжтэй байдаггүй аж.

Нийгэм, хүмүүнлэгийн танин мэдэхүйд эрх мэдлийн гүйцэтгэдэг үйлийн тухай постструктуралистуудын ийм үзэл нь: аливаа бүтээлийг зохиогч бол зохиолоо ухамсраараа бие даан бүтээгч биш, харин үзэл суртлын төлөөлөгч байдаг; уншигч бол зохиолыг хэрэглэгч төдийгүй бүтээгч байдаг; олон түмний санаа бодолд тохирдог юм (докса) бол үнэн биш, харин үнэн шиг байдаг гэх мэт энэ философидолтонд боловсруулсан олон үндэслэлтэй уялддаг.

Постструктуралист философидолтын янз бүрийн баримтлалд түүхийн мэдлэг үнэн байх бололцоо хязгаарлагдмалыг тийнхүү заадаг нь тэдгээрийг боловсруулагчид түүхийн мэдлэгийг үл тоомсорлодгоос шалтгаалдаг биш, харин түүхийн мэдлэг нь өөрийнхөө бий болдог нийгмийн нөхцөл, өөрийг нь бүтээгч (зохиогч) хоёроос болдог гэж тэд үздэг байдал мөн.

Постмодернист философидолт ба түүхийн мэдлэгийн арга зүй. Философийн салбарт 1970-аад оны сүүлийн хагасаас хойш постструктуралист-постмодернист нэгдмэл цогцолбор бий болж төлөвшиж ирсэн тухай постмодернизмын олон нэрт төлөөлөгч болон энэ философидолтыг судлаачид өгүүлсэн байдаг. Энэ нь нэн түрүүнд дараахь хэдэн шалтгаантай аж. Үүнд, нэгдүгээрт, постструктурализмын олонхи гол төлөөлөгч өөрсдийн боловсруулсан онолын баримтлалуудаа цааш нь үргэлжлүүлэн гүнзгийрүүлэх үндсэн дээр постмодернизмд (жишээ нь 80-аад онуудад Ж.Деррида, М.Фуко, Ж.-Ф.Лиотар, Ж.Бодрийар нар) шилжсэн байна. Үүнд, ертөнц бол эмх замхгүй байдаг тухай, түүх бол тохиолдлуудын хэлхээ байдаг тухай, нэр хүнд ба уламжлалт үнэлэмжүүдэд хүмүүс итгэхээ больж байгаа тухай, бодит байдал бүхэлдээ ба тодорхой хэсгүүдээрээ бүгд текст мөн тухай зэрэг постструктурализмын олон чухал баримтлал постмодернизмд орж ирсэн аж. Хүн бол орчлонгийн төв мөн гэж үздэг аль Сэргэн мандалтын үеэс эхлэлтэй гуманист уламжлалыг постструктурализм хүлээж аваагүйг постмодернизм үргэлжлүүлэн гүнзгийрүүлээд: хүн бол байгалийн өмнө хүч мөхөсдөгч, түүний олон аашны золиос мөн гэж дүгнэсэн байна. Хоёрдугаарт, философи, социологи, соёл судлал, түүгээр зогсохгүй байгалийн шинжлэл зэрэг орчин үеийн мэдлэгийн янз бүрийн төрлийн хүрээн дэх онолын баримтлалуудыг бий болгодог үндсэн талбар бол уран сайхан хэллэг мөн гэж постструктурализм, постмодернизм аль аль нь үзжээ. Энэ нь логик

ба формальчилсан сэтгэлгээний явцуу хэл биш, харин интуитив, шилжүүлгийн(метафори),уран сайхны сэтгэлгээний хэл байдаг. Гуравдугаарт, утга зохиол судлал бол постструктурализм, постмодернизм хоёрын аль алины нь философидолтын объект ба арга болдог.

Ийнхүү постструктурализм, постмодернизм хоёр агуулга ба арга зүйн тодорхой хэсгүүдээрээ нийлж, нэгдмэл нэг цогцолбор болдог.

Постмодернизмын хувь заяаны талаархи сэтгэгдлээ илэрхийлж оросын философич И.А.Гобозов "Түүхийн философийн удиртгал" хэмээх номондоо бичихдээ: өнөөдөр "...шинжлэх ухааны бие даасан салбар болох философийг хэрэг дээрээ устгасан янз бүрийн иррационалист баримтлал ба урсгал рационализмын халаанд хүрч ирлээ. Энд постмодернист ба постструктуралист урсгалуудад онцгой "гавъяа" оногддог... Тэдгээр нь объектив бодит байдлыг танин мэдэх хамгийн дээд хэлбэр болох шинжлэх ухааныг хэрэг дээрээ таягдаж байна. Тэдгээр урсгал атомын энерги ба даяарчлалын эрин болох манай эринд иррационализмыг номолж байна. Улмаар хүн төрөлхтөн XXI зуун руу постмодернист ба постструктуралист үзэл санаатай орвоос XX зуунд амжаагүй асуудлуудаа шийдвэрлэж чадна гэж тооцоолох бололцоогүй юм. Гэхдээ янз бүрийн постмодернист баримтлал XX зуунд үлдээд, Оюун ухаан дахин өндөр авч, үүний ачаар хүн төрөлхтөн хөгжин боловсронгуй болно хэмээн бид найдцагаа"¹⁸ хэмээн бичсэн юм.

Постмодернистууд И.А.Гобозовын харамсал, хорсол шингэсэн ийм үгэнд хариулт өгье гэвэл ямар ч байсан дараахь зүйлсийг тэд дурдах болов уу гэж бодож байна (тийм бодол надад зөн совингоор биш, харин тэдний бүтээлүүдийнх нь агуулгаас төрж байгаа юм). Үүнд:

-“Постмодерн” гэдэг франц хэлэн дэх тэмдэг нэр нь XX зууны 70-аад оны сүүлийн хагасаас хойшхи үеийн өндөр хөгжилтэй нийгмүүдийн мэдлэгийн төлвийг, харин “постмодернизм” гэдэг нэр томъёо нь тийм мэдлэгийн төлөв, шинжийн тухай философи баримтлалуудын цогцыг тус тус илэрхийлнэ гэж постмодернистууд (жишээ нь Ж.-Ф.Лиотар) тайлбарладаг.

-Постмодернизмын үүднээс хандвал ертөнцийг материалист, символист, ер бусын хүчний бүтээл гэж бишрэх зэрэг ямар ч загвараар авч үзэх байдал, бас амьдралыг аль нэг шаталсан дэг журамтай гэж үзэх гэх мэт бол аль аль нь бололцоогүй ба ашиггүй байдаг. Хэрэв ертөнцийн загварын тухай ярих хэрэгтэй юм бол энэ талаархи аливаа холбогдох үзлийг магадлалт шинж ба магадлалт үнэлэмж бүхий байдгаараа адил гэж тэдгээрт хандах хэрэгтэй хэмээн постмодернизмд үздэг аж. Ийм байр суурь нь постмодернистууд философийн тогтолцоо бүтээхийн оронд философи-уран сайхны янз бүрийн эссе зохиоход хүргэдэг ажээ.

Ийм учраас текстүүдийг тайлбарлах зарчмууд боловсруулах нь постмодернист философидолтын чухал зорилт байдаг.

-Постмодернистууд философи дахь рационалист, аналитик чиглэлүүдийг үл зөвшөөрдөг нь философи танин мэдэхүйд Оюун ухаан тодорхой ач холбогдолтойг цулгүй үгүйсгэсэндээ биш, харин Тэр (Оюун ухаан) нь иррациональ зүйлстэй гарцаагүй холбогдож байж философи баримтлалууд боловсруулдаг, тодруулж дурдвал философи баримтлалууд бол зөвхөн логик сэтгэлгээний биш, бас түүний хамт хүртэхүй, догдлон мэдрэхүй, заншил, цухалдал зэрэг психик үйл явцын үр дүн болж байдаг гэж үзсэнийх мөн.

-Шинжлэх ухааныг зөвхөн логик сэтгэлгээ, Оюун ухааны бүтээл мөн гэж үзэхийг постмодернистууд бас учир дутагдалтай, өрөөсгөл гэж үздэг юм. Тухайлбал Ж.-Ф.Лиотар шинжлэх ухаан бол логик ба логик биш олон хүчин зүйлийн бүтээл мөн гэж тайлбарладаг. Тэрээр легитимаци (ёсчлохуй), тодруулан дурдвал тухайн хэллэг шинжлэх ухааны шинжтэй хэмээн зөвшөөрөгдөх янз бүрийн нөхцлийн холбогдох шаардлагануудын цогц, судлаачийн төлөвшил, арилжааны хэрэгсэл болох бололцоо, хэлний оролцооны байдал зэрэг хүчин зүйлс аваас шинжлэх ухааны мэдлэгийн хүлээн зөвшөөрөгдөхөд гарцаагүй чухал гэжээ.

-Шинжлэх ухааны легитимаци нь аль Платоны үед төрийн хууль тогтоогчийн легитимацитай гарцаагүй холбоотой явж ирсэн аж. Өөрөөр хэлбэл, "юу үнэн, юу худлаа вэ?" гэдгийг тогтоох эрх (легитимаци) угтаа "юу шударга (зөв) вэ?" гэдгийг шийдвэрлэх эрхээс хамаарч ирсэн түүхтэй ажээ. Ийм учраас өөр өөр засаглалд захирагдсан хэллэгүүд өөр өөр уг чанартай байдаг. Мэдлэг, информаци бол удирдлагын асуудал болж лавширч буй орчин үеийн нөхцөлд шинжлэх ухааны тийм давхар легитимаци дан болох биш, харин ч улам бүр бэхжиж байгаа тухай Ж.-Ф.Лиотар бичжээ.

-Шинжлэх ухааны ба позитивист, шинжлэх ухааны биш (философийн, урлагийн гэх мэт) аливаа мэдлэг нь өөр өөр хэллэгийн цогцоор бүтэж, тэдгээр нь өөр өөр дүрмээр тоглох тоглоомчид руу ханддаг тул аль нэгний нь оршихуйн шаардлага нөгөөгөөсөө илүү юм уу бага гээд байх хэрэггүй гэсэн дүгнэлт постмодернистууд хийсэн байдаг. Ж.-Ф.Лиотар шинжлэх ухаанаас бусад төрлийн мэдлэгийг "нарратив" гэж нэрлээд, нарратив мэдлэг нь шинжлэх ухааны мэдлэгийн үр хөврөлийг агуулсан байдаг учир шинжлэх ухааны мэдлэгийг нарратив мэдлэгээс салгах юм уу боловсруулж авах тухай ярьж болно гэж үзжээ.

Шинжлэх ухааны мэдлэг бол нарративын хөгжингүй хэлбэрүүдийн адил рациональ ба иррациональ аль аль элементийн нэгдэл тул түүнийг (шинжлэх ухааныг) мэдлэгийн бусад төрлөөс дээгүүр юм уу доогуур тавиад байх аргагүй гэдэг дүгнэлтэнд постмодернистууд хүрсэн ажээ. Ийм дүгнэлт нь нэн түрүүнд үнэлэмжийн ба тэмдгийн онолын уялдаат үнэлгээний үр дүн болохоос мэдлэгийн янз бүрийн төрлийн практик үр өгөөжийн

асуудлыг онцлоогүй гэмээр байдаг. Энэ бол аливаа төрлийн мэдлэгийн агуулга нь үнэнээр биш, харин сэтгэцийн ба нийгмийн янз бүрийн хүчин зүйлсээр тодорхойлогддог гэдэг тэдний үзэлтэй уялдаж иржээ.

Постмодернизмын философидолт аваас орчин үеийн философи сэтгэлгээг ганцаараа төлөөлөх чадвартай гэвэл яарсан дүгнэлт болох биз. Гэхдээ түүний онол, арга зүйн баримтлалуудыг философийн амьдралын талбараас бүрэн арчигдаасай гэж хорсон хүсэх юм бол орчин үеийн мэдлэгийн янз бүрийн төрлийн төлвийг шинжлэхэд тэдгээрийн нөлөөлж буй эерэг ач холбогдлыг зөвхөн философичдын тодорхой хэсэг төдийгүй нийгмийн ба хүмүүнлэгийн ухааны төлөөлөгчид зөвшөөрч байгааг олж хараагүй, эсвэл олж харахыг хүсэхгүй байгаагийн илрэл болох юм.

Өрнөдөд түүхийн судалгаанд постструктурализм, постмодернизмын баримтлалуудыг арга зүйн хувьд ашиглаж байгаагийн үндсэн дээр түүх бол хүмүүнлэгийн мэдлэг мөнхий хувьд "удаахь түүх (post-history)" болж байгаа тухай философи үзэл эдүгээ онол, арга зүйн хувьд боловсорч байгаа юм.¹⁹

Some philosophical conceptions which should be considered as methodology in our historical investigation

Professor at National University of Mongolia
Science Doctor Ts.Gombosuren

Abstract

In this article I have seriously concerned about the theoretical conceptions which had and still have the innovating and altering impact on knowing history in Western, but have been nominally mentioned in philosophical works of history. As the author fulfill the purpose he argued that German philosopher and linguist Wilhelm von Humboldt and Austrain philosopher and linguist Ludwig Wittgenstein's linguistic philosophical conception, and French philosopher and anthropologist Claude Levi-Strauss's structuralism, and French Philosopher Michel Foucault's structural and poststructural conception, also French philosopher Jaques Derrida and Jean-Francois Lyotard's postmodern conceptions which have an important influence on western historical investigation as methodology since last-half of twentieth century. For example:

W.Von Humboldt examined that language is through mediator between subject and object also for people, universe and God. L.Wittgenstein philosophized that the fact that world is my world is expressed that only understood language boundary by me is my world boundary.

C.Levi-Strauss noticed from structural point of view that if a historical knowledge is a conscious knowledge the knowledge will be subjective and unfair.

When M.Foucault embodies structural philosophization he suggested that history is understanding of discontinuity for continuity in history therefore the absence of regularity, absoluty and stability is understood for a man of keen observation but while he transfered to poststructuralism he expected that an author of any work is not an independent producer of the work but is a representative of ideology and a reader is not only a user but also producer.

Poststructuralists set up the conceptions concerning that world is irregular, history is a set of uncertainty (eventuality), people cease to believe in the authority and traditional values and the reality is the text wholly or partly. These conceptions are entering into postmodernism.

Иш татсан зохиол

1. Л.Мөнх-Эрдэнэ. Түүхийн гүн ухааны лекцүүд. УБ., 2000
2. See: A Dictionary of philosophy. Revised Second edition. Editorial consultant Antony Flew. New York, 1984, P.148-149; The Cambridge Dictionary of Philosophy. Ed.. R. Audi. Cambridge University Press. 1996.
3. См. об этом: И.А.Гобозов. Введение в философию истории. Второе, переработанное, и дополненное издание. М., Теис, 1999
4. См. об этом: А.А Ивин. Философия истории. М., Гардарики, 2000
5. См. об этом: напр.: Философский энциклопедический словарь. М., Инфра, 1998, с.483; Современная западная философия. Словарь. 2-е изд., переработанное и дополненное. М., ТоН, 1998, с. 434-437; Современный философский словарь. Москва-Минск,..., Панпринт, 1998, с. 370-378
6. Вильгельм фон Гумбольдт. Язык и философия культуры. Сборник. М., Прогресс, 1985, с.370
7. Вильгельм фон Гумбольдт. Избранные труды по языкознанию. М., Прогресс, 1984, с.75
8. Л.Витгенштейн. Логико-философский трактат. М., 1958, с.81
9. Там же
10. Там же, с.82
11. К.Леви-Стросс. Структурная антропология. М., 1983, с.181
12. Там же
13. М.Фуко. Археология знания. Киев, 1996, с.11. М.Фуко "түүх" гэдэг нэр томъёогоор түүхийн ухаан, хүн төрөлхтний түүх аль алиныг илэрхийлдэг. Иймд тухайн тохиолдолд аль утгаар ярьсныг нь анзаардаг байх ёстой.
14. Там же, с.11
15. См. об этом: там же, с.11-12
16. См. Об этом там же, с.23-24
17. См. об этом: Жак Деррида. О почтовой открытке от Сократа до Фрейда и не только. Мн., 1999, с.692
18. И.А.Гобозов. Введение в философию истории, с.12-13
19. См. об этом: Постмодернизм. Энциклопедия. Минск., 2001, с.595-598